



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.09.15 № 36

Г Төрийн албаны реформын талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна.

Монгол Улсын Засгийн газраас өргөн барьж Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримлах бодлогын тэргүүлэх чиглэл”-д “Төрийн албаны реформ: Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж тусгагдсан.

Иймд 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх дээрх тогтоолын хүрээнд төрийн албаны реформыг хэрхэн зохион байгуулах талаар:

1. Төрийн албан хаагчдын тоог бууруулах шалгуур тогтоосон эсэх, тус реформыг хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээ болон холбогдох баримт мэдээлэл;

2. Төрийн албан хаагчийн ямар ангилалд хэдэн албан хаагчийг цомхотгоо ор төлөвлөсөн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг үйл ажиллагааны салбар болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр ангилан холбогдох мэдээллийг ирүүлнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Л.МӨНХБАЯСГАЛАН



2025000050